

Аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын үүсэл хөгжил, танилцуулга

Манай аймаг анх 1942 онд байгуулагдаж жилдээ 562.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг барилга, оёдлын 2 артель бүхий үйлдвэр хоршооллын артель, цэцгийн тос боловсруулах завод 4, талхны цех зэрэг үйлдвэр үйлчилгээний салбар бүхий жилдээ 700 орчим мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүнсний үйлдвэр ажиллуулж байжээ.

2004-2007 онд манай аймгийн хувьд Цайрт минериал, Баянцогт мөнхийн гал 2009 онд Баян-Эрч, Эрвэн хүдэр гэх зэрэг тоомоохон уул уурхайн компаниуд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллагчид, зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг.

Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан, тооллого, судалгааны материал нь болдог.

2008 оноос эхлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцож байна.

Аж үйлдвэрийн салбарын ангилал:

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал (IV хувилбар)-ыг 2009 оноос эхлэн мөрдөж байна.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхлэдэг нэгжийг тэдгээрийн дотор мэдэгдэхүйц өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь үндсэн салбарт оруулдаг

Аж ахуйн нэгж байгууллагын тоо


2011 оны **бизнес регистрийн санд** бүртгэлтэй 521 ААН байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа 491, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 30 ААНБ байна. Үйл ажиллагаа явуулахгүй байгаа ААНБ-ын шалтгааныг авч үзвэл эхлээгүй 13, бүрэн зогссон 3, түр зогсоосон 13 байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 46.1 хувийг ХХК, 22.2 хувийг ТБ, 7.2 хувийг ЗБН, 5.5 хувийг ББН, 4.4 хувийг хоршоо, 12.0 хувийг ТББ, 1.7 хувийг ОНӨҮГ, 0.3 хувийг ТӨҮГ,

0.1 хувийг ХК тус тус эзлэж байна. Өмчийн хэлбэрээр авч үзвэл 74.4 хувь буюу 388 нь хувийн, 24.7 хувь буюу 129 нь төрийн өмчит, 0.7 хувь буюу 4 нь орон нутгийн өмчтэй байна. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоог эдийн засгийн салбарын ангилалаар хүснэгтээр харуулбал:

ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар

Үйлчилгээ	ААНБ	Өөрийн өмчтэй үйлдвэр	АИӨ-ийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй, хувийн өмчтэй үйлдвэр, өмчийн өмчтэй	ААНБ	ААНБ-ын өмчтэй үйлдвэр, хувийн өмчтэй үйлдвэр, өмчийн өмчтэй	Өөрийн өмчтэй үйлдвэр, хувийн өмчтэй үйлдвэр, өмчийн өмчтэй	Өөрийн өмчтэй үйлдвэр, хувийн өмчтэй үйлдвэр, өмчийн өмчтэй	Өөрийн өмчтэй үйлдвэр, хувийн өмчтэй үйлдвэр, өмчийн өмчтэй
2007	394	2	7	3	8	102	12	6	
2008	385	4	8	5	8	110	20	9	
2009	424	4	8	5	11	135	24	10	
2010	421	3	7	3	12	154	24	8	
2011	521	4	19	5	14	167	29	9	

Үйлчилгээ	Өөрийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй үйлдвэр	Өөрийн өмчтэй үйлдвэр
2007	30	13	47	36	62	51
2008	11	8	50	35	58	50



ХАА-н, Барилгын салбарт 2.6 хувь, Уул уурхай, олборлох, Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжид 1.7 хувь, Боловсруулах үйлдвэрт 3.6 хувь, Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарт 32.0 хувь, Зочид буудал зоогийн газарт 5.5 хувь, Тээвэр агуулахын аж ахуй, холбоонд 1.7 хувь, Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаанд 2.3 хувь, үл хөдлөх хөрөнгө түрээс бизнесийн үйл ажиллагаанд 4.9 хувь, Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалд 9.2 хувь, боловсролын салбарт 7.6, Эрүүл мэндийн салбарт 11.3 хувь, Нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд 14.0 хувь нь тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд


аж үйлдвэрийн эзлэх байр суурь

/ салбарын ангиллаар /

/сая.төг/

Салбар	2007	2008	2009	2010	2011*
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	35.8	37.1	34.7	48.0	55.8
Аж үйлдвэр, барилга	104.0	56.8	63.3	66.7	74.9
Үйлчилгээ	10.7	22.7	16.1	18.4	22.7
Дүн	150.5	116.6	114.0	133.1	153.5

Урьдчилсан гүйцэтгэлээр 2011 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 153.5 сая төгрөгт хүрсэн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн эзлэх хувь 2007 онд 69.1 хувь, 2008 онд 48.7 хувь, 2009 онд 55.5 хувь, 2010 онд 50.1 хувь, 2011 онд 48.8 хувийг тус тус эзлэж байна.



**2011
2.8**


Нэг хүнд ногдох ДНБ нь 2007 онд 2.7 сая, 2008 онд 2.1 сая, 2009 онд 2 сая, 2010 онд 2.4 сая, 2011 онд 2.8 сая төгрөг тус тус ногдож байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн
/ 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг /

Аж үйлдвэрийн салбар	2007	2008	2009	2010	2011	2011/ 2010 %
Уул уурхай, олборлох	28669.5	30545	29635.1	24118.4	23184	96.1
Боловсруулах аж үйлдвэр	68.0	82.2	154.2	276.7	413.5	149.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	2599.6	3252.5	3899.3	3997.6	4586.6	114.7
Үүнээс: ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	307.9	230.8	215.4	213	217.2	102.0
ДҮН	31675.9	34146.2	33904.0	28675.7	28401.3	99.0

2005 оны зэрэгцүүлэх үнээр аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь 28.4 тэрбум төгрөг болсон нь урьд онуудын нийт бүтээгдэхүүнээс буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 5 жилээр графикаар харуулбал:



Оны үнээр аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2011 онд 99.6 тэрбум төгрөг болсон нь 2007 онтой харьцуулахад 39.8 тэрбум төгрөг, 2010 онтой харьцуулахад 5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Борлуулалт буурсан нь экспортлож буй бүтээгдэхүүний ханш буурсантай холбоотойгоор борлуулалт нь нөлөөлсөн. Мөн зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлохгүй болсонтой холбоотой юм. БНХАУ-д 2007 онд зөвхөн цайрын баяжмалыг экспортолж байсан бол 2010 оноос цайрын баяжмал, хүрэн нүүрс,


төмрийн хүдэр, молибдений баяжмалуудыг экспортолж байсан. Харин 2011 онд цайрын баяжмал, хүрэн нүүрс экспортлож байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн

/оны үнээр/

Аж үйлдвэрийн салбар	2007	2008	2009	2010	2011	2011/ 2010 %
Уул уурхай, олборлох	137962.7	72690.8	98775.1	101081.6	94520.5	93.5
Боловсруулах аж үйлдвэр	76.6	198.4	329.5	649.8	1047.9	161.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	1118.7	2670.1	2837.5	2916.8	3783	129.7
Үүнээс: ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	283.2	217.8	222.1	230.1	243	105.6
ДҮН	139441.2	75559.3	101942.1	104648.1	99594.4	95.2

Дээрхи бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2011 оны борлуулалтаар бүтцээр нь авч үзвэл:



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2007 онтой харьцуулахад 2011 онд архинаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Харин өнгөрсөн онтой зэрэгцүүлбэл: талх, хиам, дулаан, нүүрс, эсгий, блок, өнгөт тоосго, боржуур, замын хавтангийн үйлдвэрлэлт өсч, цайрын баяжмал, нарийн боов, ул боовны үйлдвэрлэлт буурч, төмрийн хүдэр, молибдений баяжмал, архи, цахилгааны үйлдвэрлэлт хийгдэхээ больсон байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	2011/ 2010 %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Нүүрс	мян.тн	68.7	113.1	60.9	119.6	191.9	160.5
Цайрын баяжмал	мян.тн	136.3	143.6	141.3	112.5	104.7	93.1
Төмрийн хүдэр	мян.тн	-	-	-	10.8	-	-
Молибдений баяжмал	мян.тн	-	-	0.5	0.1	-	-
Боловсруулах үйлдвэрлэл							
Талх	тн	63.1	79.2	109	329.2	425.5	129.3
Нарийн боов	тн	26.7	40.4	68.4	82.4	58.9	71.5
Ул боов	тн	-	-	-	24.4	19.3	79.1
Хиам	тн	-	-	4.2	2.8	4.2	150.0
Архи	мян.л	3.7	2	1	-	-	-
Блок	мян.ш	35	63.9	19.2	32.0	219.5	6.8*
Улаан тоосго	мян.ш	-	-	75.9	-	-	-
Өнгөт тоосго	мян.ш	-	-	15.8	11.3	13.6	120.4
Замын хавтан	м2	2858.5	2000.1	1908.3	2843	3996.6	140.6
Боржуур	м3	46.8	39.9	200.2	5*
Эсгий	мян.м	...	0.8	6.8	2.8	4	142.9
Маягт	мян.х.д.х	...	-	22.7	-	-	-
Ном	мян.х.д.х	...	-	3.6	-	-	-
Цахилгаан, дулаан, усан хангамж үйлдвэрлэл							
Цахилгаан	мян.кв.цаг	305.1	272.5	248.1	-	-	-
Дулаан	мян. гкал	60.6	67.1	77.5	83.3	96.8	116.2

2.Барилга:

Бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын үйл ажиллагаа явуулж байгаа 14 ААН байгууллага байна. Аймгийн хэмжээнд 7.6 тэрбум төг-ийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь өнгөрсөн оноос 1.9 тэрбум төг-өөр буюу 25.8 хувь, мөн 2007 оныхоос 90.3 хувиар тус тус өссөн байна. 2011 онд 14 барилга, байгууламж ашиглалтанд орсон. Нийт ашиглалтанд орсон барилга, байгууламжийг төрлөөр нь авч үзвэл: Орон сууцны барилга 2.9 тэрбум төг, эмнэлгийн барилга 160.0 сая, сургууль, соёлын барилга 427.4 тэрбум төг, далан, суваг, шугам сүлжээ 12 сая, зам талбай 242.9 тэрбум төгрөгөөр тус тус баригджээ.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2011/ 2010
Барилга угсралт их, засварын ажил	736.9	3449.6	1750.2	5656.3	7624.4	134.8
Ашиглалтанд оруулсан барилга, байгууламж	9	13	17	14	14	100.0

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг сүүлийн 6 жилийн байдлаар графикаар харуулбал:



Тухайн аймгийн нутаг дэвсгэр дээр худалдааны үйл ажиллагаа явуулах, орчин нөхцөл бололцоо.

Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт 82.3 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг эзлэн, урд талаараа БНХАУ, баруун талаараа Дорноговь, баруун хойт талаараа Хэнтий, зүүн талаараа Дорнод аймагтай тус тус хиллэдэг.

Аймаг 2011 онд 15.8 мянган өрх, 55.1 мянган суурин хүн амтай болсон бөгөөд нийт өрхийн 50.7 хувь буюу 7.9 мянган өрх аймаг, сумын төвд амьдарч байна.

Нийт хүн амын 51.2 хувь нь хөдөө, 48.8 хувь нь аймаг сумын төвд амьдарч байгаа ба 66.7 хувь нь 15-59 насны хөдөлмөрийн насны хүн байна.

3. Худалдааны салбарын үүсэл хөгжил ба өнөөгийн байдал

Худалдааны салбарт 167 ААН Байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа.


Худалдааны графикт мэдээнд хамрагдаж үйл ажиллагаа явуулж байгаа 34 Аж ахуйн нэгж байгууллагад 79 хүн ажиллаж байна.

Нийт борлуулалтын орлого 5648.6 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 49.8 хувиар буюу 2817.7 сая төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй байна.

Худалдааны салбарын гүйцэтгэл сонгогдсон /ААНБ/-аар

Үзүүлэлт	Нийт орлого /сая.төг/				Ажиллагсдын тоо				Мэдээлэлд хамрагдсан байгууллага			
	2008	2009	2010	2011	2008	2009	2010	2011	2008	2009	2010	2011
Эм, гоо сайхны барааны жижиглэн худалдаа	130.9	79.4	146.9	63.6	13	17	8	6	2	1	1	2
Бусад төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	1 967.0	1 812.7	2 830.9	5 648.6	90	29	72	77	40	19	19	33
Бүгд	2 097.9	1 892.1	2 977.8	5 712.2	103.0	46	80	83	42	20	20	34


Худалдааны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Худалдааны нэг цэгт ноогдох хүний тоо, аймаг

Үзүүлэлт	2008	2009	2010	2011
Сүхбаатар	91	86	66	63

Худалдааны нэг цэгт ноогдох хүний тоог графикаар харуулбал:



4. Холбооны үйлчилгээний орлого радио телефон цэгийн тоо

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо,хөдөлгөөнт холбоо,мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.

Үүрэн телефон хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

Утасгүй холбооны хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгч .


Интернет кафе Олон нийтэд нэг цэгт интернет үйлчилгээ үзүүлэгч байгуулагаа аж ахуйн нэгж

2011 онд 339.9 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувь буюу 15.8 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас орох орлого нь нийт орлогын 48.3 хувийг эзэлж байна.

Холбооны салбарын үзүүлэлтүүд / оноор /

Үзүүлэлт	хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011
Нийт орлого	сая.төг	521.9	444.8	333.1	324.1	339.9
Хүн амаас орох орлого	сая.төг	273.4	197.6	145.3	156.7	166.7
Телефон цэг	ш	1527	1422	1710	931	850

Холбооны салбарын гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Суурин телефон цэгийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 9.2 хувь буюу 81-ээр буурсан байна.

Сүүлийн жилүүдэд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо өсч байна.

Тус аймгийн иргэд, хөдөлмөрчид Ньютел, Скайтель, Юнитель, Жи мобайл зэрэг үүрэн телефоны хэрэглэгч болсноор холбооны орлого болон суурин телефон хэрэглэгчийн тоо буурах хандлагатай болж байна. Тээвэр холбооны салбарт аймгийн нийт ажиллагсдын 1.5 хувь нь буюу 388 хүн ажиллаж байна.

5.Тээврийн салбарын тээсэн ачаа,зорчигчдын тоо,ачаа эргэлт,зорчигч эргэлт

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт,тээсэн ачаа,зорчигч эргэлт,авто машины тоо,шилжүүлсэн тонн,км ажиллагсдын тоо орлого зэрэг орно

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд дамжуулдаг,

Ачаа эргэлт Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ


Шилжүүлсэн тонн км Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

Тээвэр бүхий байгууллагууд 2011 онд 187.6 мян.тн ачаа тээвэрлэж, 25.1 мян.хүн тээвэрлэж, ачаа эргэлт 45925.8 мян.тн.км, зорчигч эргэлт 12051.0 мян.хүн.км-ийн ажил гүйцэтгэж, нийт орлого 5323.0 сая төгрөгт хүрлээ. Тээсэн ачаа 2007 оныхоос 7.3 мян.тн-оор буурч, 2010 оныхоос 6.5 хувиар буюу 12.3 мян.тн-оор өсч, 2007 оныхоос зорчигч эргэлт 0.2 хувиар буюу 305 мян.хүн.км-ээр буурч, 2010 оныхоос 24.4 хувиар буюу 2951.8 мян.хүн.км-ээр өссөн байна. Тээврийн байгууллагын тээсэн ачаа, ачаа эргэлтийн эдийн засгийн үзүүлэлт буурч байгаа нь тус аймагт Цайрын баяжмалыг гадны байгууллагаар гүйцэтгэх болсонтой холбоотой юм.

Тээврийн салбарын гүйцэтгэл:

Үзүүлэлт	хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	%
Тээсэн ачаа	мян.тн	194.9	149.6	188.2	175.3	187.6	93.1
Ачаа эргэлт	мян.тн.км	5 505.4	42 141.2	54 874.6	48 248.2	45925.8	87.9
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	25.6	22.1	13.6	22.8	25.1	167.6
Зорчигч эргэлт	мян.хүн.км	12 356.0	8 853.8	7 210.0	9 099.2	12051	126.2
Тээврийн орлого	сая.төг	275.9	5 922.0	6 603.8	5 108.0	5323	77.3

Тээврийн салбарын гол үзүүлэлт болох тээсэн ачаа, зорчигч тээвэрлэлтийг графикаар харуулбал:




Манай аймгийн хэмжээнд авто техникийн 2011 оны улсын үзлэгээр бүх төрлийн авто машин нийт 3.8 мянга болсны 52.6 хувь буюу 2.0 мянга нь суудлын авто машин, 44.0 хувь буюу 1.6 мянга нь ачааны, 4.5 хувь буюу 162 автобус, 1.0 хувь буюу 12 тусгай зориулалтын авто машин байна. Нийт авто машиныг ашиглагдсан хугацаагаар ангилж авч үзвэл: 9.9 хувь буюу 388 машин нь 10 хүртэлх жил 90.1 хувь буюу 3496 машин нь 10-аас дээш жил ашиглагджээ. Өнгөрсөн оноос 9 хувиар авто машины тоо өсчээ.

Улсын үзлэгийн дүнтэй харьцуулбал: нийт авто машины тоо 1.3 хувийг эзэлж байна.

Авто машины тоо /төрлөөр/

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	төрлөөр			
						суудлын	Ачааны	автобус	тусгай зориулалтын
Авто машины тоо	2452	2 632	3 427	3 529	3 884	2 023	1 687	162	12
Улсын дүн	161989	190 459	224 068	254 486	312 542	208 514	75 090	22 547	6 391



Дүгнэлт, санал

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд явагдаж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотойгоор олгогдож байгаа зээлээс улбаалан аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн, нийт үйлдвэрлэлт, борлуулалтыг нэмэгдүүлж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнээр улсад 2011 онд 8-р байр эзлэж байна. 2011 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2.8 сая төгрөг болсон байна.

Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдэж, бизнес эрхлэж амьдрал ахуйгаа дээшлүүлж байгаа иргэдийн тоо нэмэгдэж, ард иргэдийн амьдрал дээшилж байгаа бөгөөд манай аймгийн худалдааны салбарт нөлөөлөх нэг давуу тал нь БНХАУ-тай хөрш зэргэлдээ оршиж худалдаа наймаагаа хөгжүүлж байгаа явдал юм. Тухайн аймгийн худалдааны салбарын нийт орлого жил ирэх тутам өсч байгаа нь манай хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэд, бизнес эрхлэгчдийн маань хүчин зүтгэл, мөн банкны байгууллагуудын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж олгож байгаа зээл, бөөний сүлжээний төв байгуулж төсөл хэрэгжүүлж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

2009 оноос манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг бүрдүүлсэн.

Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа бөгөөд тээврийн ачаа болон зорчигч тээврийн орлого үйлчилгээний хэмжээ өссөн үзүүлэлтэй байна.

Холбооны салбарын хувьд түлхүү хөгжиж ирсэн нь харагдаж байна. Тус аймаг шилэн кабелийн сүлжээнд холбогдож, техник технологийн шинэчлэлт хийсэн нь олон давуу талыг харуулж байна. Гэвч холбооны салбарын эдийн засгийн үзүүлэлт жил ирэх тутам унаж байна.

Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг нь бидний хувьд ямарч мэдээлэл дүгнэлт байдаггүй нь дутагдалтай.

Хойшид үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээрхи санал:

- Шинээр худалдааны чиглэлээр бий болж байгаа ААН Байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэрийн хоёр хүн дарга, нягтлан гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, АШБ хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.
- Манай статистикийн 21-ний мэдээний хугацаатай ААН-дийн мэдээлэл таардаггүй энэ нь мэдээг 15-наас авдаг учир тайлан гараагүй байдагтай холбоотой юм.
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй хотоос үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн компани байна. Энэ компанийн мэдээллийг оршин байгаа дүүргийн статистикийн хэлтсээр авахуулж авч болох эсэх.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2008 2009, 2010, 2011 оны гүйцэтгэлээр харууллаа.

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ, тайлан

ДНБ-ний тооцоо улс, аймаг, он оны статистикийн эмхтгэл

Хүн ам өрхийн бүртгэлийн сангийн үзүүлэлт зэргийг ашиглав.

Танилцуулга бичсэн

Д.Улаанхүүхэн